

ТАНИЛЦУУЛГА

Журам батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэж заасан.

Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэгт “Тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрүүлэх, хянах журмыг нийгмийн даатгалын төв байгууллагад тогтооно” гэж заасан.

Дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор зорилгоор “Журам шинэчлэн батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 09 дүгээр тогтоолоор баталсан журам болон “Журам батлах тухай” Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны А/72 дугаар тушаалаар баталсан “Тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ыг тус тус мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг баталсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална” гэж заасан.

Хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулав.

2022 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 162,283 хүнд 27.4 тэрбум, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 58,471 хүнд 121.0 тэрбум төгрөг, оршуулгын тэтгэмжийг 14,215 хүнд 14.2 тэрбум, ажилгүйдлийн тэтгэмжийг 30,516 хүнд 78.7 тэрбум, нийт 265 485 хүнд 241.3 тэрбум төгрөг тус тус олгожээ.

Харин 2023 оны 9 дүгээр сарын байдлаар хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 104,067 хүнд 22.6 тэрбум төгрөг, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 46,117 хүнд 108.1 тэрбум төгрөг, оршуулгын тэтгэмжийг 10,597 хүнд 21.2 тэрбум төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжийг 23,143 хүнд 80.4 тэрбум төгрөг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангийн 2024 оны төсөвт орлогыг 348.8 тэрбум, зарлагыг 267.5 тэрбум, ажилгүйдлийн даатгалын сангийн төсөвт орлогыг 125.9 тэрбум, зарлагыг 125.5 тэрбум төгрөг байхаар тус тус баталсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/176 дугаар тушаалаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар ажлын хэсэг байгуулж ажиллав.

Энэхүү ажлын хэсэг 3 удаа хуралдаж, журмын төслийг боловсруулав.

Журмын төслийг боловсруулахдаа Процессийн дахин инженерчлэлийн ажлын хүрээнд гарсан саналыг тусгалаа. Тухайлбал:

-нийгмийн даатгалын байгууллага өөрт байгаа мэдээллийг ажил олгогч, иргэдээс шаардахгүй;

-иргэд өмнө нь 6 хүртэл баримт иргэд бүрдүүлдэг байсныг тэтгэмжийн төрлөөс хамааран 1-3 хүртэл баримт бичиг бүрдүүлэхээр багасгалаа. Тухайлбал жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах даатгуулагч зөвхөн эмнэлгийн хуудас бүрдүүлэх ба энэ нь цахим болсон;

-иргэд дээрх 3 хүртэл баримт бичгийг цахимаар ирүүлж үйлчилгээ авах боломжийг бүрдүүллээ.

Энэхүү журмыг боловсруулсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 09 дүгээр тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгох шаардлагатай.

“Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолыг баталснаар даатгуулагч, ажил олгогчид үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх, гомдол маргааныг шуурхай шийдвэрлэх, хяналтыг сайжруулах, үйл ажиллагааг цахимжуулах, ил тод болгох зэрэг олон зэрэг өөрчлөлт гарна.

Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт санхүүжилт шаардагдахгүй болно.

.....oOo.....